



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин 89 хувьтай байна



Өлгий

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган</p> <p>Аудитын менежер Х.Женисбек</p> <p>Ахлах аудитор К.Риза</p> <p>Аудитор Р.Баярмаа</p> <p>2018 оны 4 дүгээр сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 94156768, 99265539 дугаарын утсаар харилцана уу</p> <p>ХАЯГ:</p> <p>Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 105, 106, 108 тоот өрөө</p>	<p>Товчилсон үгийн тайлбар 3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4-5</p> <p>Бүлэг 1 Төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн хөтөлбөр, бодлогод нийцүүлэн төлөвлөсөн байна. 6-9</p> <p>Бүлэг 2 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна 10-19</p> <p>Бүлэг 3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлууд зохиох үр өгөөжөө өгч байна. 20-21</p> <p>Дүгнэлт..... 22</p> <p>Холбогдох байгууллагын санал: 23</p> <p>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал</p> <p>..... 24</p> <p>Саналд өгсөн тайлбар</p>
--	---

Товчилсон үгийн тайлбар

ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ХХААХҮСайд	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхий аудиторос баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад өгөхөд аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад УИХурал, яамдууд, аймаг, сумдын ИТХурал, Засаг дарга, ЗДТГазраас гаргасан холбогдох шийдвэрүүд, Худалдан авах ажиллагааны нэгжээс зохион байгуулсан ажлын үр дүн, ажлын явцын болон холбогдох санхүүгийн ажлын тайлан, бусад тооцоо судалгаа үйл ажиллагаануудыг хамрууллаа.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, харилцан ярилцлагад тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Гүйцэтгэлийн аудитын журам, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, ОНӨГазрын худалдан авах ажиллагааны холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, санал, асуулга, лавлагаа авах, фото, судалгаа авч дүн, шинжилгээ хийх, зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Асуудлын талаар товч мэдээлэл:

Тус аймагт Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр 4513,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээг 1752,3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд 300,4 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

1. Төрийн аудитын тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
6. Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
7. Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
8. Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ахлах аудитор К.Риза, аудитор Р.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хуваарийн дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдалд гүйцэтгэлийн аудит хийж аудитын тайланг бэлтгэв.

Аудитын тайлангийн хавсралт судалгаа мэдээнүүдийг тайланд хавсаргав.

Бүлэг 1

*Төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн хөтөлбөр, бодлогод
нийцүүлэн төлөвлөсөн байна*

Оршил

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 19-ныг хүртэлх хугацаанд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Гүйцэтгэлийн аудитад 2017 онд Улсын төсвийн хөрөнгөөр Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг бүрэн хамруулав.

Улсын төсвийн хөрөнгөөр Баян-Өлгий аймагт 2017 онд шинээр хэрэгжих 9, он дамжин хэрэгжиж байгаа 1, нийтдээ 4513,2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 1720,3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлжээ.

А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн байна.

А.1. Төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн хөтөлбөр, бодлогод нийцүүлэн төлөвлөсөн байна.

А.1.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, салбарын бодлого, стратегитэй нийцсэн төсөл, арга хэмжээг баталжээ.

Баян-Өлгий аймагт 2017 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, салбарын бодлоготой уялдсан байна.

А.1.2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулахад төсвийн зарчим, хууль журмаар тогтоосон шаардлагыг баримталж ажилласан байна.

2017 онд аймгийн хэмжээнд шаардлагатай Хөрөнгө оруулалтын ажлын төслийг салбарын байгууллагуудаас ирсэн саналыг үндэслэн аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтсээс нэгтгэн, шаардлагатай тооцоо судалгааны хамт аймгийн Засаг даргаар хянуулан батлуулжээ.

Дээрхи хөрөнгө оруулалтын жагсаалтыг харьяа салбарын яам, Сангийн яаманд хуулинд заасан хугацаанд буюу 2016 оны 8 дугаар сарын 15-ны дотор хүргүүлсэн байна.

А.1.3. Ашиглагч байгууллагын хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн төсөл, арга хэмжээнүүд батлагджээ.

Тус аймагт 2013-2020 онуудад хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналын эрэмбэлсэн жагсаалт болон салбарын удирдах байгууллагуудын санал, аймгийн Засаг даргаар батлуулсан 2017 онд хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл арга хэмжээний жагсаалт, төсвийн байгууллага, иргэдийн санал, хөрөнгө оруулалт шаардлагатай объектийн бодит байдалд хийсэн МХГазрын улсын байцаагчийн дүгнэлт зэргийг харгалзан хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл, арга хэмжээнүүдээс нэн шаардлагатай төсөл арга хэмжээнүүд 2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтанд орж батлагдсан байна.

А.1.4. ТЭЗ-даас нэн шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлж оруулсан байна.

2017 онд улсын төсвийн хөрөнгөөр Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн Өлгий сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн засвар, Дэлүүн сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны засвар, Толбо сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны сантехникийн засвар, Улаанхус сумын Согоог дунд сургуулийн биеийн тамирын заалны их засвар, Бугат сумын Бүрэн дунд сургуулийн дээврийн ажил, Ногооннуур Сум дундын эмнэлгийн шугам сүлжээний засварын ажил, Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийг цэвэр усны шугамд холбох зэрэг 8 засварын ажил, аймгийн Эрүүл мэндийн газарт мотоцикль нийлүүлэх ажлын хамт 9 төсөл арга хэмжээ нь орон нутгаас нэн шаардлагатай гэж эрэмбэлсэн төсөл арга хэмжээнүүд байна.

А.2. Шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна.

А.2.1. Нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхой төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

2017 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийн нэр, хэрэгжих хугацаа, байршил нь тодорхой ба ашиглагч байгууллага нь тодорхойгүй төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй бөгөөд хэрэгжих явцад төсөл арга хэмжээний нэр, хугацаа, байршилд өөрчлөлт ороогүй байна.

А.2.2. ТЭЗҮ хийгдсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж батлуулсан байна.

2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж шинээр хэрэгжихээр батлагдсан Өлгий сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн засвар, Дэлүүн сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны засвар, Толбо Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны сантехникийн засвар, Улаанхус сумын Согоог дунд сургуулийн биеийн тамирын заалны их засвар, Бугат сумын Бүрэн дунд сургуулийн дээврийн ажил, Ногооннуур Сум дундын эмнэлгийн шугам сүлжээний засварын ажил, Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийг цэвэр усны

шугамд холбох зэрэг бүгд 8 засварын ажлын мэргэшсэн төсөвчнөөр гаргуулсан зураг төсөл, аймгийн ЭМГазарт нийлүүлэх мотоциклийн үнийн судалгаа, техникийн тодорхойлолт зэрэг хөрөнгө оруулалтын хэмжээг тогтооход үндэслэл болгох зураг төсөв, тооцоо судалгааг захиалагч байгууллагаас урьдчилан бэлтгэж, харьяа яаманд хүргүүлсэний дагуу яамнаас хөрөнгө хуваарилагдсан байна.

А.2.3. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд техник нөхцөл олгогдсон байна.

2017 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд нь ашиглаж байгаа барилга объектийг засварлах ажлууд байгаа ба Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийг цэвэр усны шугамд холбох ажилд холбогдох байгууллагуудаас техникийн нөхцөл олгогдсон байна.

А.2.4. Тайлант онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн зураг төсөвт өөрчлөлт ороогүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт эрх шилжүүлэн 2013 оноос он дамжин хэрэгжиж байгаа Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны барилга угсралтын ажил нь 73 хувийн ажлын гүйцэтгэлтэйгээр 2017 онд шилжин хэрэгжиж ашиглалтанд оржээ. Сургуулийн барилгын зураг төсөвт өөрчлөлт ороогүй, дахин магадлал хийгдээгүй байна.

А.2.5. Хөрөнгө оруулалтын шинжтэй биш төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.

2017 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээг төлөвлөөгүй байна.

А.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл хангагджээ.

А.3.1. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан хуваарь гарган батлуулжээ.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл, худалдан авах тоног төхөөрөмжийн актанд захиалагчийг төлөөлж гарын үсэг зурах эрх бүхий барилгын хяналтын болон санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан холбогдох албан тушаалтнуудыг томилж, томилсон тухай шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Мөн төсөл арга хэмжээний санхүүжилтийн хуваарийг гарган батлуулж, хуваарийг Сангийн яаманд хүргүүлжээ.

А.3.2. 2017 оны худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг зохих шаардлагын хэмжээнд хугацаандаа боловсруулж, батлуулсан байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-д заасны дагуу эрх шилжсэн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл

арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ТЕЗ-даас эрх шилжүүлсэн шийдвэрийг үндэслэн 2017 онд хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийг Орон нутгийн өмчийн газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 5 дугаар сараас 10 дугаар сарын хооронд баталж оруулсан байна.

А.3.3. Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эрхийг ажил гүйцэтгэх боломжтой хугацаанд шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргад БСШУЯамны сайдын 2017 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн А/173 тоот тушаалаар Өлгий сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг, Дэлүүн сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны засвар, Толбо сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны сантехникийн засвар, Улаанхус сумын Согоог дунд сургуулийн биеийн тамирын заалны их засвар, Бугат сумын Бүрэн дунд сургуулийн дээврийн ажлын, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 170 тоот тушаалаар Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийг цэвэр усаар хангах ажлын, Эрүүл мэндийн яамны сайдын 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/285 тоот тушаалаар Ногооннуур Сум дундын эмнэлгийн шугам сүлжээний засварын ажлын эрхийг тус тус орон нутагт шилжүүлсэн байна.

ХХААСайдаас аймгийн ХХААГазрын засварын ажлын зөвхөн худалдан авах эрхийг Аймгийн Засаг даргад шилжүүлжээ.

Эрүүл мэндийн яамны сайдын 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/285 тоот тушаалаар ЭМГазарт мотоцикль худалдан авах ажлын бүх эрхийг аймгийн ЭМГазрын даргад шилжүүлжээ.

ТЕЗ-аас эрх шилжүүлсэн хугацааны хувьд Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийг цэвэр усаар хангах ажлаас бусад ажлуудыг ажил гүйцэтгэх боломжтой хугацаанд шилжүүлсэн байна.

Бүлэг 2

*2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл,
арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.*

Б. 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагджээ.

Б.1.1. Төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт нь зохих шаардлагын дагуу боловсруулагдсан байна.

Захиалагчаас боловсруулж, эрх бүхий зураг төсөвчнээр хийлгэсэн ажлын даалгавар, зохих стандартын шаардлага, норм номативт үндэслэн зориулалтыг бүрэн заасан техникийн тодорхойлолтыг боловсруулан гаргасан байна.

Б.1.2. Үнэлгээний хороог зохих журмын дагуу байгуулж, тендерийн баримт бичгийг хугацаанд нь боловсруулсан байна.

Үнэлгээний хороог Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь зүйлд заасан шаардлагыг хангахуйц худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, АЗ сертификаттай, худалдан авах ажиллагааны салбарын мэргэжилтнүүд болон аймгийн ЗДТГ-ын ажилтнуудын төлөөллийг оролцуулан 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажилласан байна.

Захиалагчаас тендерийн бичиг баримтыг тендерийн урилга тараахаас өмнө боловсруулан тендерт оролцох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдэд урилгын хамт тараасан байна.

Эрүүл мэндийн газарт мотоцикль нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулжээ.

Дээрхи төсөл арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийг ажил тус бүр дээр байгуулсан үнэлгээний хороо сонгон шалгаруулжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Улаанхус сумын Согоог багийн сургуулийн биеийн тамирын заалны их засварын ажил, Толбо сумын сургуулийн барилга, сантехникийн засвар, Дэлүүн сумын сургуулийн барилгын их засварын ажил, Бугат сумын сургуулийн шувуу нурууны дээврийн ажил, аймгийн ХХААГ-ын байрны засварын ажлын төсөл арга хэмжээнүүдийн баримтанд үнэлгээний хорооны гишүүд “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг

зөвшөөрсөн мэдүүлэг”, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн маягтуудыг хууль журмын дагуу бүрэн гүйцэд хөтөлж, гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Тус аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2017 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах бараа, ажил үйлчилгээний товч тодорхойлолт, тендерийн бичиг баримт, тендерт оролцогчдын ирүүлсэн тендер зэргийг цахим болон цаасан хэлбэрээр төсөл арга хэмжээ бүрээр архивын нэгж болгон хадгалсан байна.

Архивлан нэгжилсэн баримт материалд үнэлгээний хорооны тайлангийн зарим баримт бичгийн бүрдэл дутуу, гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Б.1.3. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын аргыг зөв сонгосон байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газраас тогтоосон босго үнийг баримтлан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 6 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар, босго үнийн дээд хязгаараас дээш төсөвт өртөгтэй 145,0 сая төгрөгийн өртөг бүхий Дэлүүн сумын сургуулийн барилгын их засварын ажил, 100,0 сая төгрөгийн өртөг бүхий Толбо сумын сургуулийн барилга, сантехникийн засварын ажлын тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулж явуулжээ.

2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Засгийн газрын ХААУХШМ-ийн системд оруулан Өглөөний сонинд нийтэлж, аймгийн “Tender.gov.mn”, “Tender.bo.gov.mn”, “bayan-ulgii.gov.mn”, “e-procurement.mn”, “meps.gov.mn” сайтуудаар нийтэд зарлан мэдээлж, гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан байна.

Эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийг цэвэр усны шугамд холбох төсөл арга хэмжээнд үнэлгээтэй холбоотой зөрчил гарч тендер шалгаруулалтыг хүчингүй болгож гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг дахин зохион байгуулжээ.

Б.1.4. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь зохих газарт нь хүргүүлж байжээ.

Худалдан авах ажиллагааны тайлан мэдээг улирал бүр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг мэдээлэх, тайлагнах журмын 1, 2 дугаар хүснэгт маягтын дагуу гаргаж аймгийн Засаг даргаар батлуулан, улирал бүр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Б.2. Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг үндэслэлтэй боловсруулсан байна.

Б.2.1. Барилга, байгууламжийн зураг төсөлтэй холбоотой ямар нэгэн маргаан зөрчил гараагүй байна.

2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт 13 засварын ажилд мэргэшсэн, тэргүүлэх зэрэгтэй барилгын төсөвчнөөр зураг, төсөл гаргуулсан байна. Зураг төсөлтэй холбоотой ямар нэгэн маргаан зөрчил гараагүй байна.

Б.2.2. 2017 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн зураг төслийн дагуу гүйцэтгэхэд барилгын норм дүрэм зөрчигдсөн, үнийн хэлбэлзэл үүссэн зэргээр төсөвт өртөгт өөрчлөлт орсон асуудал гараагүй байна.

Б.2.3. Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийг анх батлагдсан зураг төсөл, төсөвт багтаан гүйцэтгэжээ.

Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдэд өөрчлөлт ороогүй байна. Ашиглагч байгууллагын хүсэлтээр бүх төсөл арга хэмжээнүүдэд магадлашгүй ажлын зардлаар нэмж төсөв батлуулан хэрэгжүүлсэн байна.

Б.2.4. Хийгдсэн барилга засварын ажлуудад зохиогчийн хяналт хийгдээгүй байна.

Тайлант онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэнд зохиогчийн зүгээс хийсэн хяналтын талаар ямар нэгэн акт, ажлын тэмдэглэл үйлдэгдээгүй байгаагаас үзэхэд зохиогчийн зүгээс зохих хяналт тавьж ажиллаагүй байна гэж үзэх үндэстэй байна.

Зураг төсвийн зардалд 9,6 сая төгрөгийг төсөв зохиогчдод олгосон байна.

Б.3. Гүйцэтгэгч байгууллагууд гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.

Б.3.1. Гүйцэтгэгч компаниудын ажиллах хүчин, техник хэрэгсэл, машин механизмийн хүрэлцээгүйгээс шалтгаалан ажил саатсан тохиолдол гараагүй байна.

Гүйцэтгэгч байгууллагуудын ажлын гүйцэтгэл, ажлын явцын хяналт хийсэн мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт, материалтай танилцаж үзэхэд тухайн жилд гүйцэтгэгч компаниудад ажиллах хүчин, техник хэрэгсэл, машин механизмийн хүрэлцээгүйгээс болж ажил саатсан тохиолдол гараагүй байна.

Б.3.2. Гүйцэтгэгч барилга, угсралтын ажлыг зураг, төсөв, гэрээний дагуу хугацаанд нь гүйцэтгэжээ.

Тайлант онд он дамжин хэрэгжсэн Өлгий сумын Ерөнхий боловсролын 2 дугаар бүрэн дунд сургуулийн хичээлийн байр барих төсөл болон 2017 онд шинээр улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 8 төсөл арга хэмжээ захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ, батлагдсан зураг төсвийн дагуу хугацаандаа хэрэгжсэн байна. 2017 онд шинээр эхэлсэн төсөл арга хэмжээнүүдээс Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийг цэвэр усаар хангах төсөл арга хэмжээ нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтанд гомдол гарсантай холбоотой тухайн онд хэрэгжээгүй байна.

Аудитын явцад Дэлүүн, Толбо, Бугат, Өлгий сумдад 2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, эдгээр сумын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд БСШУЯ, ЭМЯамнаас нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байдал, ашиглалтыг газар дээр нь шалгаж үзлээ.

Орон нутагт эрх шилжсэн төсөл арга хэмжээнүүдээс Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн хичээлийн байр, Өлгий сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг, Дэлүүн сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны засвар, Толбо сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны сантехникийн засвар, Улаанхус сумын Согоог дунд сургуулийн биеийн тамирын заалны их засвар, Бугат сумын Бүрэн дунд сургуулийн дээврийн ажил, Ногооннуур Сум дундын эмнэлгийн шугам сүлжээний засварын ажлыг ашиглалтанд актын дагуу хүлээн авч, ашиглалтанд оруулсан байна.



Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн хичээлийн байр



Дэлүүн сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байр



Дэлүүн сумын Бүрэн дунд сургуулийн заал, хичээлийн байрны гаднах байдал



Өрхийн болон багийн эмч нарын мотоциклууд

Аудитын явцад 2017 онд улсын төсвийн хөрөнгөөр тус аймагт хуваарилагдсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэлийг орлого авсан эсэх, ашиглаж байгаа эсэхийг шалгаж үзэхэд:

а/ Эрүүл мэнд, спортын сайдын багцаас 2017 онд авто машин, эмнэлгийн тархины цахилгаан бичлэгийн аппарат, автоклав, флюорографын аппарат зэрэг эмнэлгийн тоног төхөөрөмж болон 6 авто машин нийтдээ 399.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хуваариласан байна.

Эдгээр эмнэлгийн тоног төхөөрөмж, авто машиныг орлогод авсан эсэхийг хуваарьт байгууллагуудаас шалгаж үзэхэд Алтай сумын ЭМТөвд хуваарилсан 29,7 сая төгрөгийн үнэтэй “Фургон” авто машиныг Алтай сумын ЭМТөвд олгоогүй байсан ба Алтай сумын ЭМТөв нь 2016 оны 11-сард автомашин авсан байжээ.



ЭМЯмнаас нийлүүлсэн эрүүл мэндийн тоног төхөөрөмжүүд



Сумын ЭМТөвүүдэд нийлүүлсэн автомашин

Тухайн үед Алтай сумын ЭМТөвд өгсөн уг автомашиныг Онцгой байдлын Ерөнхий газраас түр зээлээр авсан бөгөөд оронд нь 2017 онд Алтай сумын ЭМТөвийн хуваарьт автомашиныг өгсөн гэж ЭМЯмны сайдын 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн хуваарь баталсан А/237 тоот тушаалын хавсралтыг ирүүлэхэд ЭМЯмнаас бидэнд мэдээлсэн гэж аймгийн ЭМГазрын хөрөнгө оруулалт, төсөв хариуцсан мэргэжилтэн тайлбар өгсөн болно.

в/ Боловсрол Соёл Шинжлэх ухааны яамнаас хуваарилагдсан 277,4 сая төгрөгийн хөрөнгөнөөс Өлгий, Бугат, Дэлүүн, Толбо сумдын сургууль, цэцэрлэгүүдэд хуваарилагдсан сургалтын тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу хүлээн авч, сургалтандаа ашиглаж байна.

Харин сургуулиудад нийлүүлсэн 211840 ам.доллорын өртөг бүхий шилэн кабелийн тоног төхөөрөмжийг хараахан суурилуулж, ашиглалтанд оруулаагүй байна.



БСШУЯамнаас нийлүүлсэн шилэн кабелийн тоног төхөөрөмж болон сургалтын хэрэглэгдэхүүн



БСШУЯамнаас нийлүүлсэн гал тогооны тоног төхөөрөмжүүд



Аймгийн ХХААГазрын байрны засварын ажил

Б.3.3. Захиалагчийн хяналтаар илэрсэн зөрчлүүдийг тухай бүр арилгуулсан байна.

Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэнд захиалагчийг төлөөлж үе шатны ажлын гүйцэтгэлд ЗДТГазрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Барилга захиалагчийн албаны дарга, инженерүүд газар дээр нь хяналт тавьж, зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулсан байна.

Б.3.4. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

а. БСШУСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын Төрийн сан дахь харилцах данснаас 2017 онд эрх шилжсэний дагуу 1439.7 сая төгрөгийн санхүүжилтийг дараах төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид ажлын гүйцэтгэлээр олгожээ.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн барилгын санхүүжилтэнд “Агайын” ХХКомпанид 1044.0 сая төгрөг, Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн засварын ажлын санхүүжилтэнд “Берте трейд” ХХКомпанид 37,4 сая төгрөг, Дэлүүн сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны засварын ажлын санхүүжилтэнд “Нармаржан” ХХК-д 127,0 сая төгрөг, Толбо сумын Бүрэн дунд сургуулийн сантехникийн засвар санхүүжилтэнд “Көркем” ХХК-д 94,8 сая төгрөг, Улаанхус сумын Согоог дунд сургуулийн биеийн тамирын заалны их засварын санхүүжилтэнд “Көшелик” ХХК-д 67,5 сая төгрөг, Бугат сумын Бүрэн дунд сургуулийн дээврийн ажлыг гүйцэтгэгч “Елт констракшн” ХХК-д 69,0 сая төгрөг тус тус шилжүүлжээ.

б. ЭМСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснаас 2017 онд шинээр хэрэгжсэн Ногооннуур Сум дундын эмнэлгийн шугам сүлжээний засварын ажлын санхүүжилтэнд “Алтай шар говь” ХХКомпанид 40,0 сая төгрөг олгосон байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 14.4-д заасны дагуу гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн захиалагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан эрх олгосон албан тушаалтнаас хянасаны дараа “Хяналтын хүснэгт”-ийг бөглөж, Сангийн яаманд хүргүүлж журамд заасан хугацаанд санхүүжилтийг олгосон байна.

ЭМЯамны сайдаас аймгийн ЭМГазрын даргад эрх шилжүүлэн хэрэгжсэн Аймгийн ЭМГазарт мотоциль нийлүүлэх ажлын 10,8 сая төгрөгийн санхүүжилт нь 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дансанд оруулсанаас санхүүжилтийг гүйцэтгэгчид хугацаандаа олгогдоогүй байна.

Б.4. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг зохих түвшиндээ хэрэгжүүлсэн байна.

Б.4.1. Захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд 2 талын эрх, үүрэг хариуцлагыг бүрэн тусгасан байна.

Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд хийсэн гэрээний хэрэгжилтийг авч үзэхэд 2017 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 9, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 5 төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгжсэн байна.

Төсөл арга хэмжээний гэрээ тус бүр дээр Гэрээний ерөнхий нөхцөл, Захиалагчийн эрх үүрэг, Гүйцэтгэгчийн эрх үүрэг, Захиалагч, гүйцэтгэгчийн харилцан хүлээх үүрэг, Гэрээний нэмэлт нөхцөл, Гэрээний тусгай нөхцөлүүдийг тодорхой зааж өгчээ.

Б.4.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд захиалагчийн тавих үе шатны хяналтыг тухай бүр хэрэгжүүлж ирсэн байна.

Төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд захиалагчийг төлөөлж үе шатны ажлын гүйцэтгэлд ЗДТГазрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Барилга захиалагчийн албаны дарга, инженерүүд ажлын явц, чанар, хөдөлмөрийн аюулгүй байдалд газар дээр нь хяналт тавьж талбайн журналд тэмдэглэл үйлдэж, анхаарах зүйлд заавар, зөвлөгөө өгч дараагийн хяналтаар биелэлтийг шалгаж ажилласан байна.

Б.4.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хугацаанд нь хянаж, баталгаажуулсан байна.

Тухайн төсөл арга хэмжээний гүйцэтгэгч компаны гаргасан үе шатны ажлын гүйцэтгэлийг Барилга захиалагчийн албаны хяналтын инженерүүд газар дээр нь хяналт тавьж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Барилгын засварын ажил тус бүрт дундажаар 3-4 удаа газар дээр нь хяналт тавьж, шинээр барьж байгаа барилга байгууламжийн далд ажлын явцад байнгын хяналт тавьж, ажлын үе шатаар нь фотожуулж, акт үйлдэн баримтжуулсан байна.

Б.4.4. Төсөл, арга хэмжээний урьдчилгаа болон ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг зохих баримтыг бүрдүүлсэний дагуу олгож ирсэн байна.

Аймгийн Төрийн сангаас ажлын гүйцэтгэл, “Хяналтын хүснэгт”, ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэл зэрэг зохих баримтуудыг үндэслэн урьдчилгаа болон эцсийн санхүүжилтийг тухай бүр саадгүйгээр олгож ирсэн байна.

2017 оны эцсийн байдлаар төсвийн хөрөнгө оруулалтын данс нь 12, 4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь “Эрүүл мэндийн газарт мотоцикль нийлүүлэх” төсөл арга хэмжээний олгогдоогүй санхүүжилт болон 1 төсөл арга хэмжээний магадлашгүй ажлын зардал байна.

Б.4.5. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг тогтмол хүргүүлээгүй байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6.3-д заасны дагуу эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг тухайн орон нутгийн байгууллага сар бүр зохих маягтаар дараа сарын 03-ны дотор ТЕЗахирагчид хүргүүлэхээр заасан боловч зарим саруудын мэдээг хүргүүлээгүй байна. Цаашид хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийн мэдээг сар бүр зохих маягтаар ТЕЗахирагчид хүргүүлж байхыг холбогдох албан тушаалтнуудад анхааруулав.

Б.4.6. Ажлын зураг төсөвтэй холбоотой зөрчил гараагүй байна.

2017 онд батлагдсан төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явцад ажлын зураг төсөл, төсөвтэй холбоотой зөрчил гараагүй байна.

Б.5. Хөрөнгө оруулалтын бодлого, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн

Бүлэг 3

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлууд зохих үр өгөөжөө өгч байна.

В. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлууд зохих үр өгөөжөө өгч байна.

В.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин 89 хувьтай байна

В.1.1. Орон нутгийн төр, захиргааны байгууллагаас хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилт, үр дүнг тооцож ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар Аймгийн Засаг даргын 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэхэд тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт үр дүнг хавсралт тайлан болгон оруулж, хөрөнгө оруулалтын ажлын зорилт, үр дүн хангагдсан гэж дүгнэжээ.

В.1.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээтэй холбоотой хэрэглэгчийн зүгээс гомдол гараагүй байна.

Ашиглагч байгууллагын зүгээс тавих дотоодын хяналтын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа сум орон нутгийн болон ашиглагч байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг төсөл тус бүр дээр байгуулж ашиглагчийн хяналтыг хэрэгжүүлж ирсэн байна.

Хэрэглэгч буюу ашиглагч байгууллагыг төлөөлж, захиалагч байгууллагууд гэрээ хийж байгаа ба гэрээндээ ашиглагч байгууллагын зүгээс тавих хяналтыг тодорхой тусгаагүй боловч ТАХ-г ашиглалтанд хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд ашиглагч байгууллагын төлөөлөл зайлшгүй орж, актанд гарын үсэг зурсан байна.

Аудитын явцад 2017 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн талаар ашиглагч байгууллагуудаас санал авахад төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой гомдол гараагүй болно.

В.2. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтыг зохих журмаар хэрэгжүүлж ажилласан байна.

В.2.1. Төрийн сангийн зүгээс хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд журмын дагуу хяналт тавьж ажилласан байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын

журам"-ын 4.4-д заасны дагуу захиалгачийн санхүүжилт хүссэн материалыг хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн хянан баталгаажуулсаны дараа албан тоот, "Хяналтын хүснэгт"-ийг бөглүүлж холбогдох материалын хамт Сангийн Яамд хүргүүлж хянуулсаны дараа ажлын санхүүжилтийг олгож ирсэн байна.

Ажлын явцын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр, эцсийн санхүүжилтийг ТАХ-г ашиглалтанд хүлээж авсан акт гарсаны дараа олгосон байна. Зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг холбогдох материалыг үндэслэн шилжүүлжээ.

В.2.2. ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлуудад ТЕЗ-дын зүгээс тавих дотоод хяналтыг аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс хэрэгжүүлж, ТАХ-ний явц болон гүйцэтгэлийг хянах, санхүүжилтийг олгоход журамд зааснаар ажлын гүйцэтгэлийг үндэслэн "Хяналтын хүснэгт"-ийг бөглөх, хэрэгжсэн ТАХ-г хүлээж авах зэрэг ажлын бүх үе шатанд хяналт тавьж ажилласан байна.

В.3. Төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр орон нутгийн нийгэм, эдийн засагт тодорхой үр өгөөж гарч байна.

В.3.1. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг төлөвлөх, тооцох эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тус бүрээр үр өгөөжийг төлөвлөж тооцоогүй боловч тайлант онд төлөвлөсөн бүх төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Үүнээс үзэхэд төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр орон нутгийн нийгэм, эдийн засагт тодорхой үр өгөөж гарч байна.

В.3.2. Хөрөнгө оруулалтын бодит үр өгөөж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

ТЕЗ-даас эрх шилжүүлэн 2017 онд хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээний 94,0 хувь нь боловсролын салбарт, 3,3 хувь нь эрүүл мэндийн салбарт үлдсэн 2,7 хувь нь бусад салбарт хэрэгжсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг аль болох шаардлагатай төсөл арга хэмжээнд төлөвлөж, хэрэгжүүлж байгаа боловч тайлант онд төлөвлөсөн 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байгаа нь бодит үр өгөөж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

В.3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн асуудал гараагүй байна.

2017 онд хэрэгжсэн засварын ажлуудын төсөвт өртгийг тусгай эрх бүхий барилгын мэргэшсэн төсөвчний баталгаа өгч гаргасан зураг төсвийн дагуу тогтоож байгаа учир ажлын төсөвт өртгийг нэмэгдүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөнд чухал шаардлагатай ажлуудыг оруулж төлөвлөсөн байна.
2. Худалдан авах ажиллагаа хууль журмын дагуу явагдсан байна.
3. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
4. Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлууд бүрэн хэрэгжсэн байна.

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал


МОНГОЛ УЛС
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: (976) 7042-2453, Факс: (976) 7042-36-03,
E-mail: gylymkhan@gmail.com
http://bayan-olgi.gov.mn/

2018. 04. 26 № 2-01/483
төвийн _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус аймагт 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай танилцлаа. Аудитын үйл ажиллагаа хуулийн хүрээнд хийгдсэн байна.

Цаашид тайланд тусгасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн, холбогдох хууль, журмын дагуу төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хангаж ажиллах болно.

ОРЛОГЧ  А КАМЕЛИЯТ



00000834

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

К.РИЗА

АУДИТОР

Р.БАЯРМАА

